

АШГИЙН ТӨЛӨӨ БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг ХЗДХЯ-аас боловсруулсан “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн б шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;

¹ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2018 оны 11 дугаар сарын 20

² “25.1. Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.4. тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон..”

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйл.

³ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2018 оны 12 дугаар сарын 5

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшигүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах хүрээнд сайн дураар байгууллагдан, төрөөс хараат бусаар ашгийн төлөө бус зорилго бүхий байгууллагын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлага, бүртгэл, санхүүжилтын журам, эрх, үүргийг шинэчилсэн байна. Түүнчлэн ашгийн бус хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хориглолтыг зохицуулсан.

Мөн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хөгжлийг дэмжих, төр, ашгийн төлөө бус салбарын хамтын үйл ажиллагаа, баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлох чиг үүрэг бүхий Зөвлөл байгуулахаар төсөлд тусгасан байна.

Иймд эдгээр шинэлэг зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалzan тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

➤ Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томьёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Манай улсын хувьд 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулиар ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тогтоон, холбогдох харилцааг зохицуулж ирсэн.

Гэвч нийгмийн харилцааны өөрчлөлт, шинэчлэлээс хамаарч тухайн зохицуулалтыг нарийвчлах, улмаар хуулийн зохицуулалтыг сайжруулан шинэчлэн найруулах шаардлага тулгарсан.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд Монгол Улсад ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагаа төрөөс хараат бус, улс төрийн болон шашны үйл ажиллагаанаас ангид байх, төрөөс үл ялгаварлах, тэгш боломж олгох, нээлттэй хэлбэрээр хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих, харилцах, хамтран ажиллах зарчим хэвээр хадгалагдахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараахь байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт	Хуулийн төслийн 6, 13, 47,	Хуулийн зохицуулалтад хамрагдах

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

	хэрэгжих боломж	48 дугаар зүйл	байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дун шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дун шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн⁷ зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дун шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал⁸, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дун шинжилгээ хийж үзвэл Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараахь зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

- 1) Төрийн бус байгууллагын эрх зүйн байдлыг Иргэний хуульд заасан ашгийн бус хуулийн этгээдийн төрөлд нийцүүлэн тодорхойлж, иргэд эвлэлдэн нэгдэх эрхээ хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр хэрэгжүүлэх боломжийг тодруулан хуульчилна. Бүртгэлтэй ТББ нь “Холбоо”, “Сан”-ийн хэлбэрээр харин хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, холбоод нь бүртгэгдээгүй холбоо, хандивын гэрээний зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулахаар ялган зохицуулна. Түүнчлэн хууль зүйн хувьд холбоо, сангийн хэлбэрийг зааглан тодорхойлж, сангийн эрх зүйн байдлын онцлог зохицуулалтыг хуульчилна.
- 2) Тус хуулиар зохицуулагдах харилцааны хүрээ, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхой хуульчилж, нэр томьёог нэг мэр цэгцэлнэ. Эрх зүйн байдлыг нь тусгай хуулиар тогтоосон, албан ёсны гишүүнчлэлтэй мэргэжлийн холбоод, нийтийн чиг үүрэг гүйцэтгэж буй нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн байгууллагаас ялгах бөгөөд эдгээр байгууллагад хамаарах хуулийн үйлчлэлийн хүрээг тодорхойлно. Мөн энэ хүрээнд өнөөдөр тулгамдаад байгаа шашны байгууллага, боловсрол, соёлын болон хэвлэл мэдээлэл, эрүүл мэнд, нийтийн болон сонирхогчийн спортын ашгийн бус байгууллагыг хуулийн

⁷ Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл. www.moiha.gov.mn

⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2018 он.

этгээдийн эрх зүйн байдлын хувьд энэ хуулийн үйлчлэлд хамааруулж, харин тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой харилцааг салбарын хууль тогтоомжоор зохицуулахаар хуульчилна.

- 3) Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн зорилгын ач холбогдлыг чухалчлан, тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулна. Хуулиар холбоо, сан нь өөрийн дүрэмдээ зорилгоо тодорхой заахаас гадна зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг олон улсын ашгийн бус салбарын жишиг ангиллын дагуу тодорхойлсон байх, зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө, эсхүл санхүүжилтын талаар тодорхой заах, төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхойлох, татан буугдсаны дараа хөрөнгийг хүлээн авах этгээдийг тодорхойлох гэх мэт шаардлагыг тогтооно. Мөн холбоо, сангийн дотоод засаглал, санхүүгийн зарцуулалтад ашиг сонирхлын зэрчлэес сэргийлэх, хөрөнгө, орлого, ашгийг шууд ба шууд бусаар хандивлагч ба байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчид ашгийн төлөө бус хуулийн этгээдээс хандив, эд хөрөнгө өгөхийг хориглох зэрэг хязгаарлалтыг хэвээр хадгална.
- 4) Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нөөц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, орлогыг дүрэмдээ заасан зорилгодоо зарцуулах нөхцөл, журмыг нарийвчлан тодорхойлно. Энэхүү аж ахуй, бизнесийн үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гол зорилго, үндсэн үйл ажиллагаа байж болохгүй шаардлагыг хуульчилна. Мөн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн орлогоос ажилтаны ажлын хэлс, цалин болон зардлыг нөхөхөөс бусад үндэслэлээр үүсгэн байгуулагч, удирдах зөвлөл болон аливаа зөвлөлийн гишүүн, ажил олгогч, ажилтанд ашиг хуваарилахыг хориглоно.
- 5) Ашгийн төлөө бус хуулийн этгээдэд үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг нэгдсэн журмаар татварын хууль тогтоомжид тусгаж зохицуулна. Энэ хүрээнд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны орлого нь татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөнд хамаарах бөгөөд хувь хүн, аж ахуйн нэгжээс холбоо, санд өгсөн хандивыг тодорхой хязгаарлалтын хүрээнд татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцооюуд зохицуулна.
- 6) Нийтэд тустай үйл ажиллагааны төрөл хэлбэрийг жагсаан тодорхойлж, эдгээр үйл ажиллагааг эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийг тус үйл ажиллагаанд хандив өгсөн аж ахуйн нэгжийн татварыг тодорхой хязгаарлалтын хүрээнд татвараас хөнгөлөх, төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэхэд давуу байдал олгох, тус байгууллагын нийтэд тустай үйл ажиллагаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага дун бүхий урамшуулалтайгаар хувь нэмэр оруулж буй сайн дурын ажилтан залуусыг дэмжих татвар болон нийгмийн даатгалтай холбоотой зохицуулалтыг хуульчилна.
- 7) Төрөөс иргэний нийгмийн хөгжлийг дэмжих суурь тогтолцоог бүрдүүлэх зорилгоор иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлуудаар төртэй харилцах, зөвшилцөх, холбон ажиллах чиг үүрэг бүхий "Иргэний нийгмийг дэмжих

зөвлөл"- ийг байгуулах эрх зүйн үндсийг тогтооно. Уг зөвлөл нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд байх бөгөөд Монголын иргэний нийгмийн хөгжил, чадавхыг дэмжих хөгжүүлэх, дотоод засаглал, ёс зүйн жишгийг тогтоож хөгжүүлэх, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтлэг хөгжлийн асуудлаар төр болон олон улсын байгууллагуудтай харилцах, бүртгэлийн болон статистикийн байгууллагуудтай хамтран мэдээлэл боловсруулалт хийх, нийгэмд үйлчилдэг ашгийн төлөө бус хуулийн этгээдийн болон нийтэд тустай үйл ажиллагааны үр нөлөөг нэгтгэх, тэдгээрийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон бусад дэмжлэгт хамруулахтай холбоотой дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байхаар зохицуулна.

- 8) Төрийн зарим чиг үүргийг ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгэх нөхцөлийг үл ялгavarлах, нээлттэй, ил тод байх, хараат бус байдлыг хүндэтгэх, урьдчилсан магадлан итгэмжлэл үүсгэх замаар төрийн бус байгууллагуудын өрсөлдөх боломжийг хязгаарлахгүй байх зэрэг нийтлэг зарчимд нийцүүлэн төр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хамтран ажиллах харилцааг бизнесийн байгууллагаас ялгаатай байдлаар тогтооно.
- 9) Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт здэлж байгаа бол тухайн үйл ажиллагаатай холбоотой санхүү, татвар, үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад гаргах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Түүнчлэн ашгийн төлөө бус хуулийн этгээд төрийн чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэсэн, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагуудаас санхүүжилт авсан бол санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тухайн гэрээ байгуулсан, санхүүжүүлсэн төрийн байгууллага, олон улсын хөгжлийн байгууллага нь нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар зохицуулна.
- 10) Үйл ажиллагаа эрхэлж байгаа болон үйл ажиллагаагаа зогсоосон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн жагсаалтыг Иргэний нийгмийг дэмжих зөвлөлөөс ил тод хөтлөх, тэдгээрийг татан буулгах үндэслэл, журмыг тодорхой зохицуулахаас гадна хариуцлагын асуудлыг Иргэний хууль, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд нийцүүлэн тодорхойлно.
- 11) Шинэ хууль хүчин төгөлдөр болсонтой холбоотой шилжилтийн зохицуулалт, дагаж мөрдөх журмыг тусгана.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрлийг Иргэний хуульд нийцүүлэн тодорхойлж, иргэд зөвлэлдэн нэгдэх эрхээ хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт бүртгэгдээгүй холбоог, 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "ашгийн төлөө бус хуулийн этгээд"-ийг тодорхойлсон байна.

Ийнхүү иргэд эвлэлдэн нэгдэх эрхээ хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр эдлэх боломжтойг зааж, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрийг холбоо, сан байхаар зохицуулсан нь зүйтэй боловч Иргэний хуульд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэр болох **хоршооны талаарх зохицуулалт тусгагдаагүй** байна.

Өөрөөр хэлбэл, хоршоог “ашиг олох” зорилготой хуулийн этгээдэд тооцон Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд томьёолсон байна.

Хоршоо нь иргэдээс нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дураараа нэгдсэн, дундын эд хөрөнгийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул шууд ашиг олох зорилготой хэмээн үзэж, ашгийн төлөөх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, зарчимд нийцэн ажиллах нөхцөлийг тулгаж болохгүй юм.

Иймд хоршоог ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрээс хасах бус харин **Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.5-д** “Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.” гэсэнтэй уялдуулан хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх **хэсэгт “хоршоо”-г нэмж тусгах шаардлагатай** байна.

- Тус хуулиар зохицуулагдах харилцааны хүрээ, хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг тодорхой хуульчлах хүрээнд:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлсон бөгөөд дараах ашгийн төлөө бус зорилго бүхий хуулийн этгээд, иргэдийн нэгдэлтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэж заажээ:

- Бие даасан хуулиар зохицуулагдаж байгаа: Үйлдвэрчний эвлэл, Улаан загалмай нийгэмлэг, Нотариатчдын танхим, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Шинжлэх ухааны академи зэрэг хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
- Засгийн газрын тусгай сан, хөрөнгө оруулалтын сан;
- Онцлог бүхий харилцаа бүхий байгууллага: улс төрийн нам, улс төрийн намын дэргэдэх байгууллага, шашны байгууллага;
- Бүртгэгдээгүй холбоо.

Мөн хуулийн төслийн 4.1.7-д “нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдаж, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх үүргийг хүлээсэн, зохион байгуулалт, үйл ажиллагааг хууль, өөрийн дүрмээр нарийвчлан зохицуулдаг, төрийн зохицуулалт бүхий холбоог” нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэмээн тодорхойлсон байна.

Гэтэл Захиргааны ерөнхий хуулийн 5.1-д “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захиралжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно.” гээд төрийн захиргааны байгууллагуудаас гадна “төрийн чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээдийг “багтаасан байна.

Дээрх 2 тодорхойлолтоос үзэхэд төрийн захиргааны байгууллага нь Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн нийтлэг зохицуулалтад хамрагдах

нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд багтхааар хэт өргөн тодорхойлолт болсон байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлд заасны дагуу төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд биш харин гэрээний дагуу гүйцэтгэх үүрэгт хамаарах харилцааны хувьд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн нэгэн адил үүрэг хүлээх субъект юм.

Өөрөөр хэлбэл, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн төрөлд төрийн чиг үүргийг хуулиар шилжүүлэн авсан ашгийн төлөө бус хуулийн этгээд л хамрахаар байна. Тухайлбал, Монголын хуульчдын холбоо зэрэг мэргэжлийн холбоод

Иймд хуулийн төслийн 4.1.7-д “... төрийн чиг үүргийг хуулийн дагуу шилжүүлэн авсан...” гэсэн нэмэлт хийх нь зүйтэй байна.

Мөн хуулийн төслийн 42 дугаар зүйлд “Мэргэжлийн холбоо”-ны талаар зохицуулсан бөгөөд мэргэжлийн холбооны эрх олгох, цуцлах журмыг Засгийн газар батлахаар заасан байна.

Ийнхүү мэргэжлийн холбоог тусгайлан байгуулах, эрх олгох асуудлыг хөндсөн нь сайшаалттай боловч мэргэжлийн холбоонд тухайн зохицуулалт шаардлагатай субъектийн олонх болон дийлэнх олонхийг хамруулсан гишигчлэлтэй байхаас өөр тавигдах нийтлэг шаардлагыг тодорхойлоогүй байна.

Иймд мэргэжлийн холбоог сонгон шалгаруулахад харгалзах үндсэн нөхцөл, зарчим зэргийг тусгах нь зүйтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.”⁹ гэсэнтэй нийцэх эсэхийг магадлах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, төрийн гүйцэтгэх чиг үүргийг шилжүүлэх талаар хуульд тусгайлан заасан боловч, түүнд үндэслэн эцэслэн шийдвэр гаргах эрх нь Засгийн газарт хадгалагдаж байна .

Иймд мэргэжлийн холбооны эрхийг салбарын сайд олгохоор заасныг өөрчлен Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зохицуулалтанд нийцүүлэх шаардлагатай байна.

- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн зорилгын ач холбогдлыг чухалчлан, тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулах хүрээнд:

⁹ www.legalinfo.mn

Хуулийн төслийн 10.1-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэм нь байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны төлөвлөлт байна”, 11.1-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь дүрэмдээ заасан зорилгын хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болно”, 11.5-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулна.” гэж заасан байна.

Түүнчлэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилтийн нэг эх үүсвэр болох төлбөртэй үйлчилгээ үзүүлэх хэлбэр нь зөвхөн дүрмэнд заасан зорилгод шууд холбоотой байх шаардлагыг тусгахын зэрэгцээ ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үндсэн зорилгоо өөрчлөн ашгийн төлөө хуулийн этгээд болж өөрчлөн байгуулагдахыг хориглосон байна.

Үүнээс дүгнэхэд ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үндсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ дүрмэндээ тодорхой тусгах бөгөөд энэ нь цаашид тухайн холбоо, сангийн үйл ажиллагаа, санхүүжилтэд хяналт тавих үндсэн шалгуурын нэг болохоор байна.

Энэхүү зохицуулалт нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд төрийн бус байгууллагын зорилгыг үйл ажиллагааны чиглэлээр зааглан тодорхойлоогүй, үйл ажиллагааны чиглэлийг нь зорилго гэж үзэх, түүнчлэн зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянах боломжийг хязгаарладаг зэрэг алдааг засах дэвшилттэй зохицуулалт болсон байна.

Хуулийн төслийг дагалдан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд “орлогоо дүрэмдээ зааснаас өөр зорилгоор зарцуулсан”, “үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан” үйлдлийг зөрчилд нэмж тооцооор тусгасан байна.

Гэвч хуулийн төслийн 6.2.5 болон 11.1-д “хууль буюу дүрэмдээ зааснаар бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэсэн нь төрийн бус байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан шинжтэй, мөн санхүүжилт босгох хэлбэр болох “төлбөртэй үйлчилгээ нь дүрэмд заасан зорилгод шууд хамаарсан байх” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, зөрчсөн нөхцөлд дүрэмд заасан зорилгоос гадуур аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэх эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, “аж ахуйн үйл ажиллагааны орлогыг дүрэмд зааснаас бусад зорилгоор ашиглах” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилтийг бүрдүүлэх журмыг нарийвчлан тодорхойлох чиглэлд:

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд хуулийн этгээдийн санхүүжилтийн эх үүсвэрийг

- зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;
- хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж;

- нийтэд тустай үйл ажиллагаа явуулсны нь төлөө төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;
- холбооны хувьд гишүүний татвар;
- бусад эх үүсвэр гэж заасан байна.

Аж ахуйн үйл ажиллагаа нь “зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой” байх шаардлага тавигдаж байгаа бөгөөд үүнийг урьдчилан хэрхэн тогтоох нь эргэлзээтэй төдийгүй энэхүү зохицуулалтаар тавьж буй хязгаарлалт нь хуулийн төслийн 11.1, 11.2-т заасан аж ахуйн үйл ажиллагааг ашиг олоход биш дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эрхлэх, олсон орлогыг дүрмийн зорилгод нийцүүлэн зарцуулах гэсэн агуулгатай давхардаж байна.

Иймд энэхүү заалтыг “аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого” гэж томьёолох нь илүү ойлгомжтой байх тул эргэн нягтлах нь зүйтэй байна.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2.9, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 23 дугаар зүйлийн 23.2, 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан гишүүний татвар гэснийг гишүүнчлэлийн хураамж гэж өөрчлөх, санхүүжилтийн эх үүсвэрт мөн гадаадын улсын болон олон улсын байгууллагын тесэл, хөтөлбөрийн санхүүжилтийг нэмж тусгах нь зүйтэй байна.

Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдэлийг бусниулах, экстремист үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүнээс болон хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглосон нь хууль бус үйл ажиллагаанд оролцох эрсдлийг бууруулах, хяналтыг нэмэгдүүлэх сайн талтай ч террорист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллагыг тусгаагүй, мөн ашгийн төлөө бус хуулийн этгэдүүдийг дээрх байгууллага, хувь хүнийг талаарх мэдээллээр хэн, хэрхэн хангах нь тодорхойгүй байна.

Мөн энэ хүрээнд анхаарах нэг асуудал нь хуулийн төслийн 12 дугаар зүйлд төрөөс зaim чиг үүргээ гэрээгээр шилжүүлэх асуудлыг зохицуулсан боловч гэрээ байгуулах асуудлыг хэн эцэслэн шийдвэрлэх нь тодорхойгүй, гэрээг байгуулах процесс ажиллагааны журам, гэрээнд заавал тусгах асуудал буюу нийтлэг загвар шаардлагатай ч хэн хэрхэн батлах талаар зохицуулалт байхгүй байна.

Иймд Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасантай уялдуулан гэрээ байгуулах шийдвэрийг Засгийн газраас гаргах, мөн холбогдох процессын журмыг батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

Үүнээс гадна төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдийн хүлээх нэмэлт үүргийг тодруулах, үйл ажиллагаа болон санхүүжилтийн зарцуулалтыг тайлантай холбоотой зохицуулалт шаардлагатай байна.

Иймд холбогдох зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.

- Нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлж, эдгээр үйл ажиллагааг эрхэлж буй байгуулагад үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэгийг бий болгох чиглэлд:

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд 16 төрлийн үйл ажиллагаанд нийтэд тустай үйл ажиллагаанд багтаан тодорхойлсон боловч жагсаалтын эрэмбэ

дараалал нь оновчгүй төдийгүй нийтэд тустай үйл ажиллагааны бүх чиглэлийг бүрэн тусгаагүй, агуулга дутуу байна. Тухайлбал, нийгмийн шударга ёс, сайн засаглалын чиглэлээр явуулж буй үйл ажиллагааг орхигдуулсан байна.

Түүнчлэн хуулийн төслийн 45 дугаар зүйлд нийтэд тустай үйл ажиллагааг баталгаажуулах журмыг заасан боловч Иргэний нийгмийн дэмжих зөвлөл нь тайланг ямар шалгуураар, хэрхэн үнэлж, дүгнэлт гаргах нь тодорхойгүй байна.

Иймд нийтэд тустай үйл ажиллагааны батлагаа олгох журмыг Засгийн газар батлахаар заасан байх боловч ил тод байдал, шударга ёс, хараат бус байдлыг хангахтай холбоотой үндсэн шалгуурыг хуулиар тодорхойлох нь чухал юм.

- Иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлуудаар төртэй харилцах, зөвшилцэх, холбон ажиллах чиг үүрэг бүхий "Иргэний нийгмийг дэмжих зөвлөл"- ийг байгуулах эрх зүйн үндсийг тогтоох хүрээнд:

Хуулийн төслийн 47 дугаар зүйлд Иргэний нийгмийг дэмжих зөвлөлийн чиг үүргийг тусгасан байна.

Хууллийн төсөлд ирүүлсэн санал болон холбогдох төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалтаар Зөвлөлийн чиг үүрэг, бзтэц, зохион байгуулалттай холбоотой дараах санал гарч байна:

- Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн зорилгыг нийтэд тустай, ашгийн төлөө бус салбарын хөгжлийг хангах бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг нэмэх;
- Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд иргэний нийгмийг төлөөлөх салбарыг 5 болгон нэмэгдүүлэх, салбар тус бүрээс нэг төлөөлөгчийг тухайн салбарын байгууллагууд сонгох, сонгосон төлөөллийг шууд томилох;
- Гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 3 жил болгож богиносгох;
- Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийг иргэний нийгмийн үнэт зүйлс, зарчмыг баримтлах, судалгаа шинжилгээ хийх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахад зарцуулах, сангийн хөрөнгийн орлого, зарцуулалтын тайланг нийтэд нээлттэй байлгах зэрэг зохицуулалтыг нэмж тусгах зэрэг санал ирүүлсэн байна.

Иймд зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага тодорхойгүй, олонхийг төрийн байгууллагаас бүрдүүлэх, даргыг нь Ерөнхий сайд томилооор байгааг өөрчлөх чиглэлд анхаарах шаардлагатай байна.

- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа ил тод байх зарчмыг тогтоох хүрээнд:

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тайлагнах үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

Төслийн 13.2-т "Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь хууль, эсхүл дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа тайлагнана." гэсэн нь тайлагнах үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг бус дүрмээ баримтлах боломжтой төдийгүй тайлагнах

үүргээ хуульд зааснаас өөрөөр дүрэмдээ тусгасан бол хэрхэх нь тодорхойгүй болж байна.

Нөгөө талаар ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй болохоос бус татварын тайлан гаргах үүрэггүй мэт хязгаарлагдмал зохицуулалт болсон байна.

Түүнчлэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилд нэг удаа гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй байна.

Харин нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа болон нийтийн сан, хагас жил тутам үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж цахим хуудсандaa байршуулах үүрэгтэй ч үйл ажиллагаа, үйлчилгээ нь илүү олон нийтэд хамааралтай хэсэг болох төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа болон мэргэжлийн холбоонд энэ үүргийг хүлээлгээгүй байна.

Иймд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тайлганх үүргийн зохистой байдлыг эргэн харж, зохицуулалтыг нарийвчлах, хуулийн төслийн 13.8-т нэмэлт оруулж, үүрэгжүүлсэн субъектийн хүрээг нэмэгдүүлэх, мөн тайлан гаргах давтамжийг төслийн 44.4-тэй нийцүүлэх шаардлагатай байна.

Мөн хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулах субъектэд ашгийн төлөө хуулийн этгээд хамаарч байгаа тул үүсгэн байгуулагчийн эрхийг эдлэхээс бус удирдах болон гүйцэтгэх албан тушаалд төлөөллөө оролцуулах, шийдвэр гаргахад нөлөөлөх эрсдлийг хаах зохицуулалтыг нэмэх, эсхүл зөвхөн хувийн сан болон эдийн засгийн холбоо байгуулах эрхтэй байхаар хязгаарлан зохицуулах боломжтой эсэхийг нягтлах шаардлагатай байна.

- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн татан буулгах үндэслэл, журмыг тодорхойлж, холбогдох хариуцлагыг Зерчлийн тухай болон Эрүүгийн хуульд нийцүүлэн тодорхойлох хүрээнд:

Хуулийн төслийн 17 дугаар зүйлд дараахь үндэслэлээр ашгийн төлөө бус хуулийн этгээдийг сайн дурын үндсэн дээр болон албадан татан буулгахаар зохицуулсан байна.

Сайн дурын үндсэн дээр	Албадан татан буулгах
<p>Эрх барих байгууллага(Холбооны бүх гишүүдийн хурал, Сангийн удирдах зөвлөл)</p> <ul style="list-style-type: none">- зорилгодоо хүрсэн;- үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан;- дүрэмд заасан бол бусад үндэслэл.	<p>Шүүх</p> <ul style="list-style-type: none">- Дампуурсан;- Гэмт хэргийн улмаас татан буулгах арга хэмжээ оногдуулсан;- Улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдсэн;- Улс төрийн үйл ажиллагаа явуулсан;- Шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан;- Үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө ажилласан;- Аливаа хэлбэрээр ашиг хуваарилсан.

Эрүүгийн хуульд зааснаар 9.5 дугаар зүйлийн 1-д "Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.", мөн зүйлийн 3-т "Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно." гэжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангид зөвхөн 2 төрлийн гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдэд татан буулгах ял шийтгэхээр байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 29.8 дугаар зүйлд заасан "Террор үйлдэх", 29.9 дүгээр зүйлд заасан "Террор үйлдэхэд бэлтгэсэн" гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд татан буулгах албадлагын арга хэмжээ оногдуулахаар байна.

Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь төлбөрийн чадваргүй болсон¹⁰ тохиолдолд нэхэмжлэгч, эсхүл хариуцагчийн өөрийнх нь шаардлагаар Иргэний шүүх дампуурсанд тооцох¹¹, гэмт хэрэг үйлдсний улмаас татан буулгах ял оногдуулах бол Эрүүгийн шүүхээс татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр байна.

Харин бусад үндэслэл буюу хуулийн төслийн 17.1.3 буюу (улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдсэн, улс төрийн үйл ажиллагаа, шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан, үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлө ажиллах, аливаа хэлбэрээр ашиг хуваарилах) 17.1.5-д заасан (хуудьд заасан бусад) үндэслэлээр татан буулгах шийдвэрийг аль шүүх гаргах нь тодорхойгүй байна.

Мөн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах үндэслэл болгон заасан дараах үйлдлийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн¹² зөрчилд тооцон торгох шийтгэл оногдуулахаар заасан байна.

- Улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдсэн;
- Улс төрийн үйл ажиллагаа явуулсан;
- Шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан;
- Үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө ажилласан;
- Аливаа хэлбэрээр ашиг хуваарилсан.

Харин Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлийн 3-т "Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж

¹⁰ 4.1.Өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно.

Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр зүйл.

¹¹ 5.1.Шүүх дараах үндэслэлээр дампуурлын хэрэг үүсгэнэ:

5.1.1.үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий харилцагч тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан;

5.1.2.хариуцагч үүргээ биелүүлж чадахгүй болсныг өөрөө мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан.

Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг.

¹² Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан "Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн тесел. ХЗДХЯ.2018 он. www.mojha.gov.mn

оногдуулна.¹³ Гэсэн атал Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс үзэхэд дээрх зөрчилд эрх хасах шийтгэл оногдуулах зохицуулалт байхгүй байна.¹⁴

Дээрх үйлдлээс илүү хор хохирол бүхий гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд татан буулгах ял шийтгэх боломжгүй байна.

Мөн дээрх зөрчилд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ авч, торгох шийтгэл оногдуулахын зэрэгцээ сонирхогч хэн нэгэн этгээдийн гаргасан гомдлын дагуу шүүх татан буулгахаар байна.

Иймд тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учирах эрсдэлтэй байх тул ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах үндэслэлийг тодорхой болгох, улмаар тус хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр гэмт хэрэг, зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдэл, тэдгээрт хүлээлгэх ял, шийтгэлийг оновчтой тогтооход анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн татан буулгах үндэслэлд “хуульд заасан бусад”¹⁵ гэсэн үндэслэл нэмсэн нь Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиас¹⁶ гадна бусад хуульд татан буулгах үндэслэлийг зааж болохоор хэт өргөжүүлсэн зохицуулалт болжээ.

Хуулийн төслөөр ашгийн төлөө бус хуулийн этгээдэд үүрэг болгосон, үйл ажиллагаанд нь хориглолт тогтоосон зохицуулалт цөөнгүй бөгөөд тэдгээрээс дараах үйлдэл, эс үйлдэлийг зөрчилд тооцохоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгасан байна.

11.7.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хууль зерчих		Шийтгэл
1	Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэдийн звлэлдэн нэгдэх, ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулах, гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс татгалзах эрхийг хязгаарласан бол.	хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг 50.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500.000 төгрөгөөр тортогоно.
2	2.Ашгийн төлөө бус хуулийн этгээд 2.1.орлогоос ногдол ашиг хуваарилсан; 2.2.улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчид хандив өгсөн; 2.3.орлогоо дүрэмдээ зааснаас өөр зорилгоор зарцуулсан бол	хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг 1 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 15 сая төгрөгөөр тортогоно.

¹³ www.legalinfo.mn/Сүүлчийн нэвтрэлт 2018 оны 11 дүгээр 30

¹⁴ www.legalinfo.mn /Сүүлчийн нэвтрэлт 2018 оны 11 дүгээр 30

¹⁵ Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт.

¹⁶ www.legalinfo.mn /Сүүлчийн нэвтрэлт 2018 оны 12 дугаар сарын 3

3	3.Ашгийн төлөө бус хуулийн этгээд үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан, эсхүл улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдсэн, улс төрийн үйл ажиллагаа явуулсан, эсхүл шашны байгууллагаас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан, эсхүл хувийн сан нь олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэх үйл ажиллагаа явуулсан бол	хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 3 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 30 сая төгрөгөөр торгоно.
4	4.Хуульд заасан хугацаанд санхүүгийн болон үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй бол	хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 20.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200.000 төгрөгөөр торгоно

Дээр дурдсанаас гадна хуулийн төсөлд заасан бусад хориглолтыг зөрчсөн, эсхүл үүргээ биелүүлээгүй бол ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй хэвээр байна. Тухайлбал, хориглосон эх үүсвэрээс санхүүжилт авсан, тайлан, мэдээллээ цахим хуудсандaa байршуулаагүй бол хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүй байна.

Мөн зөрчилд тооцсон үйлдэл, эс үйлдэл болон түүнд хүлээлгэх хариуцлага нь төдийлөн оновчтой бус байгааг анхаарч нягтлах шаардлагатай байна.

- Шинэ хууль хүчин төгөлдөр болсонтой холбоотой шилжилтийн зохицуулалт, дагаж мөрдөх журмыг тусгах талаар:

Хуулийн төслийн 50 дугаар зүйлд тус хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд багтаан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг улсын шинэчилсэн бүртгэлд хамрагдах шаардлагыг тусгасан байна.

2018 оны 9 дүгээр сарын бүртгэлийн мэдээллээр Монгол Улсад 19260 дотоодын ашгийн төлөө бус хуулийн этгээд, гадаад улсын болон олон улсын байгууллагын 90 төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.¹⁷

Хэдийгээр эдгээр байгууллагын дийлэнх хувь нь үйл ажиллагаа тогтмол явуулдаггүй, зогсонги байдалд байна¹⁸ гэсэн мэдээлэл байгаа боловч хамгийн багадаа 8000-9000 орчим хуулийн этгээд шинэчилсэн бүртгэлд хамрагдаж шаардлагатай болж байна.

Иймд шинэчилсэн бүртгэлийн асуудлыг нарийвчлан энэхүү бүртгэлд хамрагдаагүй байгууллагыг татан буугдсанд тооцох эсэх асуудлыг тусгайлан зохицуулах шаардлагатай төдийгүй шинэчилсэн бүртгэлд хамрагдах хугацаа бонгино байх тул хэрэгжих боломжтой байдлыг нь харгалзан өөрчлөх шаардлагатай байна.

Тухайлбал, 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлийг тус хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд багтаан хамрагдахаар заасан байна.

¹⁷ Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн танилцуулга. 2018 он. ХЗДХЯ

¹⁸ Төрийн бус байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал. 2018 он. ХЗДХЯ

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 6, 47, 48, 49 дүгээр зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зориллоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрийн байгууллага болон иргэд, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг авсан.

Мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

➤ Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 6 дугаар зүйлээр Аүгийн төлөө бус хуулийн этгээдэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглосон байна:

- улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулах;
- шашны байгууллагаас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах;
- үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө ажиллах, аливаа хэлбэрээр ашиг хуваарилах;
- улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийспэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид хандив өгөх, дэмжлэг үзүүлэх;
- хууль болон дүрэмдээ зааснаас бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;
- хуульд зааснаас бусад тохиолдолд иргэдийн эвлэлдэн нэгдэх, ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулах, гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс татгалзах эрхийг нь хязгаарлах;
- хуулиар хориглосон бусад.

Энэхүү хориглолтод заасан шашны үйл ажиллагаа явуулах, ашгийн төлөө ажиллах болон ногдол ашиг хуваарилахгүй байх, сонгуулийн үйл ажиллагаанд хандив өгөхгүй байх зэрэг нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн бус байгууллагын тухай хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Сонгуулийн хуулиаар тус тус хориглогдсон байх тул практикт үргэлжүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

Гэхдээ хуулийн төсөлд ирүүлсэн саналаас үзэхэд төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1-д ашгийн төлөө бус хуулийн этгээдэд улс төрийн хөдөлгөөнд нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлагатай гэж үзсэн байна.

Тухайлбал, Утааны эсрэг хөдөлгөөнд нэгдэж Засгийн газрыг шүүмжлэн жагсвал улс төрийн хөдөлгөөн гэж үзэх үү? Улс төрийн намуудад зориулж

бодлогын хэлэлцүүлэг хийвэл улс төрийн үйл ажиллагаа гэж үзэх үү? гэсэн асуултууд тавьсан байсан.

Үүнээс дүгнэхэд “улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн хөдөлгөөн” зэргийг тодруулах, улмаар иргэний нийгмийн гол ажил болох нөлөөллийн арга хэрэгслээс хэрхэн ялгах талаар анхаарч, зохицуулалтын томьёоллыг тодруулах нь зүйтэй байна.

➤ **Хуулийн төслийн 47, 48, 49 дүгээр зүйлийн зохицуулалт:**

Хуулийн төслийн 47, 48, 49 дүгээр зүйлд иргэний нийгмийн суурь хөгжлийн асуудлуудаар төртэй харилцах, зөвшилцэх, холбон ажиллах чиг үүрэг бүхий “Иргэний нийгмийг дэмжих зөвлөл”-ийг чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тусгажээ.

Тус зөвлөл нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд ажиллахаар зохицуулагдсан нь улсын хөгжлийн цогц бодлогод суурилах, салбар хоорондын уялдааг хангах чиглэлтэй уялдсан байх бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 7-д¹⁹ заасантай нийцсэн байна хэмээн дүгнэж байна.

Гэвч зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага тодорхойгүй, олонхийг төрийн байгууллагаас бүрдүүлэхээр зохицуулсан, даргыг нь Ерөнхий сайд томилооор байгаа нь уг зөвлөл бие дааж, хараат бусаар ажиллах баталгааг хангах эсэх, уг зөвлөлд ямар зарчмаар нэр дэвшиүүлж, төлөөллөө сонгох нь тодорхойгүй байгаа зэрэг шүүмжлэл байна.

Мөн зөвлөлийн үүрэг, хариуцлага, үйл ажиллагааг илүү тодорхой хуульчлах шаардлагатай төдийгүй зорилгыг нийтэд тустай, ашгийн төлөө бус салбарын хөгжлийг хангах бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх гэдгийг тодорхойлж өгөх, улмаар зөвлөлөөс гаргасан зөвлөмж, даалгавар нь заавал биелэгдэх шинжтэй байх зохицуулалтыг нэмж тусгах талаар иргэний нийгмийн байгууллагуудаас санал ирүүлсэн байна.

Үүнээс гадна Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийг иргэний нийгмийн үнэт зүйлс, зарчмыг баримтлах, судалгаа шинжилгээ хийх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахад зарцуулах, мөн сангийн хөрөнгийн орлого, зарцуулалтын тайланг нийтэд нээлттэй байх зарчмыг тусгах шаардлагатай байна.

Хуулийн төслийн 49.5-д “сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл батална” гэжээ.

Өөрөөр хэлбэл, тухайн сан нь Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн дэргэд ажиллах бөгөөд холбогдох шийдвэр гаргах эрх нь тус зөвлөлд хадгалагдана.

¹⁹ 4. Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна:

- улсын хөгжлийн цогц бодлого;

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

Иймд сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд тавих хяналттай холбоотой журмыг Засгийн газраас батлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

3. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсхийг нягтлан, анализ хийсэн болно.

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл нь 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатайг харгалзан 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 7 бүлэг, 51 зүйлтэй байна.

Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан

1. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
2. Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
3. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт нэмэлт оруулах тухай;
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
7. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
8. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
9. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Харин хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.” гэж заасан байх тул Төрийн бус байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй байна.

Зөрчлийн тухай хуульд оруулах өөрчлөлт болон Нийгмийн даатгалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн зохицуулалтыг дахин нягтлах шаардлагатай байна.

Тухайлбал, Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь ААН буюу ААН-ийн орлогын татвар төлөгч мөн эсэх, хэрэв тийм бол хэрхэн бүртгэгдэх, мөн татварын тайлантай холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах шаардлага бий болж байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Гэвч хуулийн төслийн зарим нэр томьёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томьёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, уг үсгийн алдааг анхаарах, шаардлагатай байна.

Хуулийн тесэлд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ХЭҮК болон холбогдох яамд, төрийн бус байгууллагууд зэрэг нийт 32 байгууллагаас²⁰ ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томьёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах талаар тодорхой саналуудыг ирүүлсэн байна.

Эдгээр саналыг харгалзан төслийн уг найруулга, бичвэрийн томьёоллыг ойлгомжтой болгоход анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал:

- ✓ Төслийн 6.3 дахь хэсэг нь 6 дугаар зүйлээр зохицуулж байгаа харилцааны агуулгад нийцээгүй, бие даасан зүйлээр зохицуулах харилцаа байх тул бичвэрийг салган томьёолох;
- ✓ Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д төлбөртэй ажил үйлчилгээ үзүүлэх замаар хандив цуглуулах гэсэн нь хууль зүйн агуулгын хувьд хандив нь хариу төлбөргүй байх гэсэнтэй зөрчилдэж байгааг засах;
- ✓ Төслийн 18.4, 26.8, 43.1, 43.3-т хэрэглэсэн эшлэл зөрч байгаа, мөн 13.3 -13.7, 33.9, 17.4, 17.5, 18.3, 47.5, 47.6, 47.8-47.12 дахь хэсэгт заасан нэр томьёо зөрүүтэй байгааг хянах;
- ✓ Төслийн 7.1.3, 7.2, 8.4, 8.5 дахь хэсгийн нэр томьёог Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулттай нийцүүлэх;
- ✓ Гадаад улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих субъектийг тодорхой болгож, тайлагнах үүргийн зохицуулалтыг тодруулах;
- ✓ Санхүүгийн болон Татварын тайлан гаргах үүргийг холбогдох хуулиэр хүлээлгэсэн тайлганх үүргээ биелүүлэх хугацаатай уялдаалан заах;
- ✓ Төслийн 8 дугаар зүйлд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэртэй холбоотой зохицуулалтыг Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх хүрээнд батладсан холбогдох журмын зохицуулалттай нийцүүлэх.

²⁰ 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ХЗДХ-ийн сайдын 1-1/5017 дугаар албан бичгийн дагуу ирүүлсэн санал

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 15 хуулийн төслийг боловсруулсан байна. Төрийн бус байгууллагын тухай хуулийг хүчингүйд тооцох тухай хуулийн төслийг нэмж боловсруулах шаардлагатай байна.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.

3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээс гадна 6 дугаар зүйлд нэр томьёог Тайлбар хэлбэрээр тусасан байна. Мен хуулийн төслийн хэлэлцүүлэг болон төсөлд ирүүлсэн санаалаас үзэхэд “ашиг хуваарилах”, “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” зэрэг нэр томвёог найруулга, бичвэрийн томьёоллын хувьд ойлгомжтой болгох шаардлагатай гэжээ.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эргэн нягтлах, тус хуулиар ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэг, хориглосон заалтыг нарийвчлан хариуцлага, хяналтын зохицуулалттай уялуулахад анхаарах.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй. Харин Хүн амын орлогын албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эргэн харж, зохицуулалтыг нарийвчла шаардлагатай байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах

			тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хуулийн төслийн 5.2, 12 дугаар зүйлд тус тус заасан байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зэрчил илрээгүй. Тус төслийн зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд байсан тодорхойгүй, мэдээлэл, санхүүжилтийн нууцлагдмал байдлыг өөрчлөн, сайжруулсан давуу талтай хэмээн дүгнэж байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулахаар тусгасан байна. Гэвч Зөрчлийн хуульд заасан хариуцлагын хэмжээ, оногдуулах үндэслэл нь давхардсан, оновчтой биш байх тул дахин нягтлан боловсруулах нь зүйтэй байна. Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

Харин хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах, нэр томьёог ойлгомжтой болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нелөө тооцох үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай" хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтуүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга,

хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлтийг хийж, Зөвлөмж боловсрууллаа:**

Дүгнэлт:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.
- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төсөлд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгож, иргэдийн эвлэлдэн эрхийн хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах, төр, иргэний нийгмийн харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн ажиллах эрх зүйн үндэслэлийг тусгасан сайшааллтай байна. Гэхдээ тус зөвлөлийн чиг үүргийг нарийвчлах, зөвлөлөөс гаргасан зөвлөмж, даалгавар нь заавал биелэгдэх шинжтэй байх зохицуулалтыг нэмж тусгах нь зүйтэй байна.
- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томьёог жигдлэх, ойлгомжтой томьёолох шаардлагатай байна.
- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зөвлөмж

Хуулийн төсөлд дараахь агуулгын чанартай зохицуулалт нэмэх, тодруулах шаардлагатай байна.

Үүнд:

1. Хуулийн төслийг дагаж Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хоршоог ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрээс хасахаар зохицуулсныг өөрчилж, Иргэний хуулийн 36.5-д "Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар

- зохицуулна." гэсэнтэй уялдуулан хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "хоршоо"-г нэмж тусгах;
2. Хуулийн төслийн 4.1.7-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1.3-т заасан захиргааны чиг үүргийг гэрээгээр бус хуулийн дагуу шилжүүлэн авсан этгээд хамаарахаар байх тул тодорхойлолтын давхцалыг арилгаж, "... төрийн чиг үүргийг хуулийн дагуу шилжүүлэн авсан..." гэсэн шинжийг нэмэлтээр тусгах;
 3. Хуулийн төсөлд ирүүлсэн санаалаас үзэхэд төслийн 6 дугаар зүйлээр хориглосон "улс төрийн үйл ажиллагаа явуулах, улс төрийн хөдөлгөөнд нэгдэх" зэрэг ойлголтыг иргэний нийгмийн гол ажил болох нөлөөллийн арга хэрэгслээс хэрхэн ялгах талаар анхаарч, зохицуулалтын томьёоллыг тодруулах;
 4. Хуулийн төслийн 6.2.5 болон 11.1, 11.2-д "хууль буюу дурэмдээ зааснаар бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх" гэсэн нь төрийн бус байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан шинжтэй байх тул "аж ахуйн үйл ажиллагааны орлогыг дүрэмд зааснаас бусад зорилгоор ашиглах" гэж өөрчлөх;
 5. Хуулийн төслийн 7 дугаар зүйлд зааснаар ашгийн төлөө ажилладаг буюу буюу ААН нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч байхаар заасныг харгалзан тул удирдах болон гүйцэтгэх албан тушаалд төлөөллөө оролцуулах, шийдвэр гаргахад нөлөөлөх эрсдлийг хаах зохицуулалтыг нэмэх, эсхүл зөвхөн хувийн сан болон эдийн засгийн холбоо байгуулах эрхтэй байхаар хязгаарлан зохицуулах боломжтой эсэхийг нягтлах;
 6. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд төрөөс зарим чиг үүргээ шилжүүлэн гүйцэтгүүлэх гэрээг байгуулах талаар шийдвэр гаргах эрхтэй субъектыг заах, гэрээг байгуулах процесс ажиллагааны журам, гэрээнд заавал тусгах нөхцөл буюу гэрээний жишиг загварыг батлах асуудлыг нарийвчилж, процессын журмыг батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг тусгах;
 7. Үүнээс гадна териийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа хуулийн этгээдийн хүлээх нэмэлт үүргийг тодруулах, үйл ажиллагаа болон санхүүжилтийн зарцуулалтыг тайлантай холбоотой зохицуулалт шаардлагатай байна.
 8. Хуулийн төслийн 13.2-т "Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь хууль, эсхүл дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа тайлгана." гэсэн нь тайлганах үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг бус дурмээ баримтлах боломжтой төдийгүй хуульд зааснаас өөрөөр тайлганах үүргээ дүрэмд тусгасан бол хэрхэх нь тодорхойгүй байх тул "эсхүл" гэсэн тодотголыг хасах, мөн ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаас гадна татварын тайлан гаргах үүрэгтэй байхаар зохицуулах;

9. Хуулийн төслийн 13.5, 13.6-д нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээд болон нийтийн сан нь хагас жил тутам үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж цахим хуудсандaa байршуулах үүрэгтэй боловч үйл ажиллагаа, үйлчилгээ нь илүү олон нийтэд хамааралтай хэсэг болох төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа болон мэргэжлийн холбоонд дээрх үүргийг хүлээлгээхгүй байна. Иймд төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа болон мэргэжлийн холбоонд үйл ажиллагаа, санхүүжилтээ ил тод, нээллтэй мэдээлэх үүргийг хүлээлгэх;
- 10.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилтийн эх үүсвэрт “гадаадын улсын болон олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт” гэж гэж нэмэх;
- 11.Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилт авч болохгүй эх үүсвэрт “террорист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжуулдэг байгууллага” гэж нэмэх, мөн гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдэлийг бусниулах, экстремист болон террорист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжуулдэг байгууллага, хувь хүнийг талаарх мэдээллээр хэн, хэрхэн хангах нь тодорхойгүй нэмэлт зохицуулалт тусгах;
- 12.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь төлбөрийн чадваргүй болсон буюу тохиолдолд нэхэмжлэгчийн шаардлагаар Иргэний шүүх дампуурсанд тооцох, гэмт хэрэг үйлдсний улмаас татан буулгах ял оногдуулах бол Эрүүгийн шүүхээс татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр заасан боловч бусад үндэслэл буюу хуулийн төслийн 17.1.3, 17.1.5-д заасан үндэслэлээр татан буулгах шийдвэрийг аль шүүх гаргах нь тодорхойгүй байх тул тодруулах;
- 13.Хуулийн төслийн 17 дугаар 17.1.3-т ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах үндэслэл болгон заасан үйлдлийг зөрчилд тооцон зөвхөн торгох шийтгэл оногдуулахаар заасан, мөн 17.1.5-д татан буулгах үндэслэлд “хуульд заасан бусад” гэсэн үндэслэл нэмсэн нь Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулиас гадна бусад хуульд татан буулгах үндэслэлийг зааж болохоор хэт өргөжүүлсэн зохицуулалт болсон байгааг анхаарч ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах үндэслэлийг тодорхой болгох;
- 14.Хуулийн төсөлд хориглосон эх үүсвэрээс санхүүжилт авсан, тайлан, мэдээллээ цахим хуудсандaa байршуулаагүй зэрэг үүргээ үүргээ биелүүлээгүй бол хэрхэн шийдвэрлэх, ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байх тул холбогдох зохицуулалтыг нэмж тусгах;
- 15.Хуулийн төслийн 42 дугаар зүйлд “Мэргэжлийн холбоо”-ны талаар зохицуулсан бөгөөд мэргэжлийн холбооны эрх олгох, цуцлах журмыг Засгийн газар батлахаар заасантай нийцүүлэн тус журамд тусгах үндсэн

нөхцөл буюу сонгон шалгаруулахад харгалзах үндсэн нөхцөл, зарчим зэргийг нэмж зохицуулах;

- 16.Хуулийн төслийн 42 дугаар зүйлд мэргэжлийн холбооны эрхийг тухайн салбарын асуудал хариуцсан сайд олгохоор зохицуулсныг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д²¹ заасантай уялдуулан Засгийн газар шийдвэрлэхээр өөрчлөх;
- 17.Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд 16 төрлийн үйл ажиллагаанд нийтэд тустай үйл ажиллагаанд багтаан тодорхойлсон боловч жагсаалтын эрэмбэ дараалал нь оновчгүй төдийгүй нийтэд тустай үйл ажиллагааны бүх чиглэлийг бүрэн тусгаагүй, агуулга дутуу байх тул эргэж нягтлах;
- 18.Хуулийн төслийн 45 дугаар зүйлд заасан Засгийн газраас батлах нийтэд тустай үйл ажиллагааны баталгаа олгох журмаар зохицуулах ил тод байдал, шударга ёс, хараат бус байдлыг хангахтай холбоотой үндсэн шалгуурыг хуулиар тодорхойлох;
- 19.Хуулийн төслийн 47 дугаар зүйлд заасан Иргэний нийгмийг дэмжих зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг тодорхой болгох, зөвлөлийн зорилгыг нийтэд тустай, ашгийн төлөө бус салбарын хөгжлийг хангах бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүргийг нэмэх;
- 20.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд иргэний нийгмийг төлөөлөх салбарыг 5 болгон нэмэгдүүлэх, салбар тус бүрээс нэг төлөөлөгчийг тухайн салбарын байгууллагууд сонгох, сонгосон төлөөллийг шууд томилооор зохицуулах, мөн гишүүдийг бүрэн эрхийн хугацааг богиносгох боломжтой эсэхийг нягтлах;
- 21.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийг иргэний нийгмийн үнэт зүйлс, зарчмыг баримтлах, судалгаа шинжилгээ хийх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахад зарцуулах, сангийн хөрөнгийн орлого, зарцуулалтын тайланг нийтэд нээлттэй байлгах зэрэг зохицуулалтыг нэмж тусгах;
- 22.Хуулийн төслийн зохицуулалтыг дагуу зөрчилд тооцсон үйлдэл, эс үйлдэл болон түүнд хүлээлгэх хариуцлага нь төдийлөн оновчтой бус байна. Иймд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр гэмт хэрэг, зөрчилд тооцох үйлдэл, эс үйлдэл, тэдгээрт хүлээлгэх ял, шийтгэлийг оновчтой тогтооход анхаарах;
- 23.Хуулийн төслийн 50 дугаар зүйлд заасан шинэчилсэн бүртгэлийн асуудлыг нарийвчлан энэхүү бүртгэлд хамрагдаагүй байгууллагыг татан буугдсанд тооцох эсэх асуудлыг тусгайлан зохицуулах, мөн 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлийг тус хуулийг дагаж мөрдсөнөөс хойш /2018.11.01/ 2 жилийн хугацаанд багтаан хамрагдахаар заасныг харгалзан хугацааг нийцүүлэх;

²¹Засгийн газар нь териийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.

24. Төрийн бус байгууллагын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулах;
25. Тус хуулийн төслийг дагалдуулан Нийгмийн даатгалын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн зохицуулалтыг нягтлах. Тухайлбал, Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь ААН буюу ААН-ийн орлогын татвар төлөгч мөн эсэх, хэрэв тийм бол хэрхэн бүртгэгдэх, мөн татварын тайлантай холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгах;
26. Хуулийн төслийн зарим нэр томьёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томьёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, уг үсгийн алдааг анхаарах.

Тухайлбал,

- ✓ Төслийн 6.3 дахь хэсэг нь 6 дугаар зүйлээр зохицуулж байгаа харилцааны агуулгад нийцээгүй, бие даасан зүйлээр зохицуулах харилцаа байх тул бичвэрийг салган томьёолох;
- ✓ Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4.1-д төлбөртэй ажил үйлчилгээ үзүүлэх замаар хандив цуглуулах гэсэн нь хууль зүйн агуулгын хувьд хандив нь хариу төлбөргүй байх гэсэнтэй зөрчилдэж байгааг засах;
- ✓ Төслийн 18.4, 26.8, 43.1, 43.3-т хэрэглэсэн эшлэл болон 13.3 -13.7, 33.9, 17.4, 17.5, 18.3, 47.5, 47.6, 47.8-47.12 дахь хэсэгт заасан нэр томьёо зерүүтэй байгааг хянах;
- ✓ Төслийн 7.1.3, 7.2, 8.4, 8.5 дахь хэсгийн нэр томьёог Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуультай нийцүүлэх;
- ✓ Гадаад улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих субъектийг тодорхой болгож, тайлангнах үүргийн зохицуулалтыг тодруулах;
- ✓ Санхүүгийн болон Татварын тайлан гаргах үүргийг холбогдох хуулиар хүлээлгэсэн тайланганах үүргээ биелүүлэх хугацаатай уялдаалан заах;
- ✓ Төслийн 8 дугаар зүйлд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэртэй холбоотой зохицуулалтыг Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх хүрээнд батладсан холбогдох журмын зохицуулалттай нийцүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Судалгаа, статистик мэдээлэл

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик бүртгэл. 2015 он.
2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл. 2018 он. ХЗДХЯ
3. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2018 он. ХЗДХЯ
4. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2018 он. ХЗДХЯ
5. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2018 он. ХЗДХЯ
6. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага, Тандан судалгаа хийсэн үнэлгээ. 2017 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.
7. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн танилцуулга. Нээлттэй төслийн хэлэлцүүлэлт ХЗДХ-ийн Дэд сайд Б.Энхбаярын танилцуулсан илтгэл. 2018.10.26
8. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага: Үндэсний болон зарим орны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа: 2018 он. Нээлттэй нийгэм форум
9. "Ашгийн бус байгууллын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалт". Эрх зүйн дүн шинжилгээ. 2017 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Төрийн бус байгууллагын тухай хууль;
4. Иргэний хууль;
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
6. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;
7. Эрүүгийн хууль;
8. Зөрчлийн тухай хууль;
9. Дампуурлын тухай хууль;
10. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол;
11. Монгол Улсын Их хурлын 2016 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол;
12. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.